

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 07 дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 181 дүгээр тогтоолын 5 дугаар хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 504 дүгээр тогтоолоор баталсан “Цахилгаан, дулааны эрчим хүчний тариф тогтоох аргачлал”-ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, “Ган-Илч” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 128 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг нэгдүгээр хавсралтаар, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон орон сууц, айл өрхөд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Баталсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Ган-Илч” ХХК (О.Ганбат)-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 152 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны 07 дугаар сарын ...-ний өдрийн
... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН, ГУРВАНСАЙХАН, ГОВЬ-УГТААЛ,
ӨЛЗИЙТ, ЦАГААНДЭЛГЭР, ДЭЛГЭРЦОГТ, САЙХАН-ОВОО СУМДЫН ТӨСӨВТ
БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

“Ган-Илч” ХХК-аас Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт		төг/м ³	3,314.0
	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	төг/ГЖ	62,968.0
		тогтмол	төг/м ³	1,707.0

---oOo---

Эрчим хүчний зохицуулах хорооны
2026 оны 07 дугаар сарын ...-ний өдрийн
... дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН, ГУРВАНСАЙХАН, ГОВЬ-УГТААЛ,
ӨЛЗИЙТ, ЦАГААНДЭЛГЭР, ДЭЛГЭРЦОГТ, САЙХАН-ОВОО СУМДЫН ҮЙЛДВЭР,
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ
ТАРИФ**

“Ган-Илч” ХХК-аас Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сумдын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	төг/м ³	2,048.0
2	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, “0”-ын өрөөний халаалт хамаарна.)	төг/м ²	1,000.0

---oOo---